



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 8/120

Мөрөн сум

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 1.1, 66 дугаар зүйлийн 1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1"в", 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны "Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай" 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогыг товлосон хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулан явуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтад дурдсанаар байгуулсугай.

2. Аймаг, орон нутгийн эдийн засгийн голлох салбарын хувьд мал тооллогын ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, малыг тооллогод бүрэн хамруулах, тооллогын мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил, дутагдлыг газар дээр нь залруулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг мал тооллогын Ажлын хэсгийн дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Мал тооллогын ажлыг аргачлал, маягт заавар, арга зүй нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын явцад хяналт тавьж, тооллогын явцын мэдээг тухай бүр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга (Б.Базардамбуу)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дүгээр сарын 25.-ны өдрийн А/425
дугаар захирамжийн хавсралт

2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МАЛ ТООЛЛОГЫН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Аймгийн Засаг даргын орлогч дарга

Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Онцгой байдлын газрын дарга

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Татварын хэлтсийн дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Статистикийн хэлтсийн дарга

---оо---